



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/042/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgаланm@audit.gov.mn Аудитор: Т.Батсүх Утас: 70453799, Цахим хаяг: Batsukht@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв
 - 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн
 - 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

Г ӨНДӨРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ Г
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЧИНЗОРИГ ТАНАА

2026.02.25 № УВА-2026/042/НА-СГА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБООУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБООУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8515050611

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	244,504,068.95	289,900,658.95
33	АВЛАГА	69,652.75	851,724.75
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	782,072.00
335	Бусад авлага	69,652.75	69,652.75
3351	Байгууллагаас авах авлага	69,652.75	69,652.75
35	БАРАА МАТЕРИАЛ	244,434,416.20	289,048,934.20
354	Хангамжийн материал	232,542,662.20	277,157,180.20
35410	Бичиг хэргийн материал	1,368,450.00	1,803,350.00
35420	Аж ахуйн материал	55,717,595.00	56,017,693.00
35450	Барилгын засварын материал	130,000.00	130,000.00
35470	Бусад хангамжийн материал	175,326,617.20	219,206,137.20
35600	Мал амьтад	11,891,754.00	11,891,754.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,898,955,096.77	1,825,185,618.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,898,955,096.77	1,825,185,618.29
392	Биет хөрөнгө	1,815,321,096.77	1,746,842,209.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,871,905,786.80	1,947,217,786.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(822,437,965.17)	(886,532,229.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	469,578,600.00	417,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(141,679,433.30)	(144,867,499.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	629,616,254.40	636,098,416.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(439,934,276.91)	(483,119,083.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,034,339.97	63,034,339.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,899,799.70)	(48,733,906.22)
39209	Зам, гүүрийн байгууламж	77,824,938.00	125,985,115.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,891,246.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	311,623,716.25	311,623,716.25
39215	Хуримтлагдсан элэгдэл	(163,311,063.57)	(187,823,199.25)
393	Биет бус хөрөнгө	83,634,000.00	78,343,409.20
39301	Програм хангамж	3,055,000.00	6,055,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,055,000.00)	(3,742,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	83,634,000.00	83,634,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(7,603,090.80)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,143,459,165.72	2,115,086,277.24
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,658,075.00	12,944,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,658,075.00	12,944,500.00
413	Өглөг	9,658,075.00	12,944,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	9,658,075.00	513,200.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,231,300.00
4136	Бусад өглөг	-	11,200,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	11,200,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,133,801,090.72	2,102,141,777.24
51	Засгийн газрын хувь оролцоо	2,133,801,090.72	2,102,141,777.24

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	746,186,599.17	746,186,599.17
51101	Өмч: - төрийн	746,186,599.17	746,186,599.17
512	Хуримтлагдсан үр дүн	1,087,561,380.91	1,055,902,067.43
51210	Өмнөх үеийн үр дүн	1,087,561,380.91	1,087,561,380.91
51220	Тайлант үеийн үр дүн	-	(31,659,313.48)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	300,053,110.64	300,053,110.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,143,459,165.72	2,115,086,277.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,765,675,871.00	1,291,378,789.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	619,089,383.00	260,825,867.93
120	Нийтлэг татварын бус орлого	619,089,383.00	260,825,867.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,560,000.00	14,906,754.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,560,000.00	3,015,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	11,891,754.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	614,529,383.00	126,046,638.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	-	119,872,475.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,146,586,488.00	1,030,552,922.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,024,188.00	4,921,322.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,100,100.00	2,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,924,088.00	2,921,322.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,101,562,300.00	1,025,631,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,101,562,300.00	1,025,631,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,359,905,829.70	1,321,295,603.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,300,867,829.70	1,309,403,849.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,194,414,595.32	1,238,431,219.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	642,544,138.55	701,007,087.12
210101	Үндсэн цалин	363,165,357.85	392,349,769.19
210102	Нэмэгдэл	254,710,641.80	270,016,407.26
210104	Урамшуулал	8,169,000.00	7,812,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,499,138.90	30,828,310.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,827,719.34	87,719,468.54
210201	Тэтгэврийн даатгал	54,673,587.81	59,430,086.35
210202	Тэтгэмжийн даатгал	6,429,886.21	6,991,774.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,649,349.71	3,818,170.17
210204	Ажилгүйдлийн даатгал	3,214,943.15	3,495,887.42
210205	Эрүүл мэндийн даатгал	12,859,952.46	13,983,549.73

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,896,735.98	46,316,305.55
210301	Гэрэл, цахилгаан	6,372,152.33	10,434,719.50
210302	Түлш, халаалт	36,524,583.65	35,781,586.05
210303	Цэвэр, бохир ус	-	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	72,620,606.00	97,862,191.00
210401	Бичиг хэрэг	6,964,100.00	3,036,850.00
210402	Тээвэр, шатахуун	59,588,006.00	24,866,884.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,983,000.00	1,338,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,434,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,085,500.00	271,002.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	66,915,455.00
2105	Нормативт зардал	150,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,136,000.00	276,500.00
210604	Урсгал засвар	7,136,000.00	276,500.00
2107	Томилолт, зочны зардал	21,656,000.00	13,180,000.00
210702	Дотоод албан томилолт	21,656,000.00	13,180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,869,273.00	2,004,837.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	203,525.00	115,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	330,428.00	603,951.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	958,000.00	-
210807	Газрын төлбөр	990,320.00	997,056.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	323,714,122.45	290,064,830.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	144,953,071.00	81,846,513.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,485,000.00	1,187,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	174,276,051.45	207,031,317.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,453,234.38	70,972,629.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,580,458.00	19,965,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,580,458.00	7,095,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	12,870,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	74,872,776.38	51,007,629.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	74,872,776.38	51,007,629.79
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	59,038,000.00	11,891,754.00
2200	Дотоод эх үүсвэрээр	59,038,000.00	11,891,754.00
223001	Бусад хөрөнгө	59,038,000.00	11,891,754.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	405,770,041.30	(29,916,813.51)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,742,499.97
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-ҮХ	-	1,742,499.97

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	-1,742,499.97
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	405,770,041.30	(31,659,313.48)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,151,146,488.00	1,033,567,922.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,560,000.00	3,015,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,560,000.00	3,015,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,560,000.00	3,015,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,560,000.00	3,015,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,146,586,488.00	1,030,552,922.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,024,188.00	4,921,322.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,100,100.00	2,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,924,088.00	2,921,322.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,101,562,300.00	1,025,631,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,101,562,300.00	1,025,631,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,142,486,488.00	1,024,610,222.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,142,486,488.00	1,024,610,222.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,036,033,253.62	953,637,592.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	634,338,951.76	710,892,034.12
210101	Үндсэн цалин	361,548,099.32	443,577,487.41
210102	Нэмэгдэл	247,399,269.50	227,092,341.11
210104	Урамшуулал	8,169,000.00	7,812,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,222,582.94	32,409,605.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,444,483.88	87,761,468.54
210201	Тэтгэврийн даатгал	54,035,228.27	59,627,392.35
210202	Тэтгэмжийн даатгал	6,347,874.23	7,004,774.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,176,758.54	3,648,864.17
210204	Ажилгүйдлийн даатгал	3,173,347.18	3,496,887.42
210205	Эрүүл мэндийн даатгал	12,711,275.66	13,983,549.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,121,735.98	46,800,155.55
210301	Гэрэл, цахилгаан	6,597,152.33	11,056,541.00
210302	Түлш, халаалт	36,524,583.65	35,643,614.55
210303	Цэвэр, бохир ус	-	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,193,222.00	21,699,474.00
210401	Бичиг хэрэг	5,715,160.00	2,269,250.00
210402	Тээвэр, шатахуун	28,719,512.00	14,779,224.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,283,000.00	1,338,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,346,550.00	2,592,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,129,000.00	721,000.00
2105	Нормативт зардал	1,125,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,125,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,899,000.00	456,500.00
210604	Урсгал засвар	8,899,000.00	456,500.00
2107	Томилолт, зочны зардал	21,656,000.00	13,180,000.00
210702	Дотоод албан томилолт	21,656,000.00	13,180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,869,273.00	2,141,937.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	203,525.00	115,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	330,428.00	741,051.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	958,000.00	-
210807	Газрын төлбөр	990,320.00	997,056.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	201,385,587.00	70,706,023.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	195,353,587.00	69,045,523.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,032,000.00	1,660,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,453,234.38	70,972,629.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,580,458.00	19,965,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,580,458.00	7,095,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	12,870,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	74,872,776.38	51,007,629.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	74,872,776.38	51,007,629.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,660,000.00	8,957,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,660,000.00	8,957,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,660,000.00	8,957,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,660,000.00	8,957,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,660,000.00	8,957,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,660,000.00)	(8,957,700.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	746,186,599.17	300,053,110.64	681,791,339.61	1,728,031,049.42
C04	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	746,186,599.17	300,053,110.64	681,791,339.61	1,728,031,049.42
C07	Тайлант үеийн үр дүн			405,770,041.30	405,770,041.30
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	746,186,599.17	300,053,110.64	1,087,561,380.91	2,133,801,090.72
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	746,186,599.17	300,053,110.64	1,087,561,380.91	2,133,801,090.72
D08	Тайлант үеийн үр дүн			-31,659,313.48	-31,659,313.48
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	746,186,599.17	300,053,110.64	1,055,902,067.43	2,102,141,777.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТ ОРЛОГО	1,146,586,488.00	1,076,639,229.79	69,947,258.21
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,024,188.00	0.00	45,024,188.00
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,101,562,300.00	1,076,639,229.79	24,923,070.21
132001	Орон нутгийн төсвөөс	1,101,562,300.00	1,076,639,229.79	24,923,070.21
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,560,000.00	3,015,000.00	1,545,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,560,000.00	3,015,000.00	1,545,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,765,675,871.00	1,079,654,229.79	686,021,641.21
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,359,905,829.70	977,638,970.21	382,266,859.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,300,867,829.70	977,638,970.21	323,228,859.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,194,414,595.32	957,673,970.21	236,740,625.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	642,544,138.55	710,892,034.12	-68,347,895.57
210101	Үндсэн цалин	363,165,357.85	443,577,487.41	-80,412,129.56
210102	Нэмэгдэл	254,710,641.80	227,092,341.11	27,618,300.69
210104	Урамшуулал	8,169,000.00	7,812,600.00	356,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,499,138.90	32,409,605.60	-15,910,466.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,827,719.34	87,761,468.54	-6,933,749.20
210201	Тэтгэврийн даатгал	54,673,587.81	59,627,392.35	-4,953,804.54
210202	Тэтгэмжийн даатгал	6,429,886.21	7,004,774.87	-574,88.66
210203	ҮОМШӨ ний даатгал	3,649,349.71	3,648,864.17	485.54
210204	Ажилгүйдлийн даатгал	3,214,943.15	3,496,887.42	-281,944.27
210205	Эрүүл мэндийн даатгал	12,859,952.46	13,983,549.73	-1,123,597.27

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,896,735.98	46,800,155.55	-3,903,419.57
210301	Гэрэл цахилгаан	6,372,152.33	11,056,541.00	-4,684,388.67
210302	Түлш, халаалт	36,524,583.65	35,643,614.55	880,969.10
210303	Цэвэр, бохир ус		100,000.00	-100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	72,620,606.00	19,734,265.00	52,886,341.00
210401	Бичиг хэрэг	6,964,100.00	2,269,250.00	4,694,850.00
210402	Тээвэр, шатахуун	59,588,006.00	12,814,015.00	46,773,991.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,983,000.00	1,338,000.00	645,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон		2,592,000.00	-2,592,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	4,085,500.00	721,000.00	3,364,500.00
2105	Нормативт зардал	150,000.00		150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00		150,000.00
2106	Эд хогшил худалдан авах	7,136,000.00	6,414,200.00	721,800.00
210601	Багаж техник хэрэгсэл		5,957,700.00	-5,957,700.00
210604	Урсгал засвар	7,136,000.00	456,500.00	6,679,500.00
2107	Томилолт, зочны зардал	21,656,000.00	13,181,000.00	8,476,000.00
210702	Дотоод албан томилолт	21,656,000.00	13,181,000.00	8,476,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,869,273.00	5,141,937.00	-2,272,664.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	288,000.00	288,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	203,525.00	115,830.00	87,695.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	330,428.00	741,051.00	-410,623.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00		99,000.00
210806	Мэдээллийн технологийн зардал	958,000.00	3,000,000.00	-2,042,000.00
210807	Газрын төлбөр	990,320.00	997,056.00	-6,736.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	323,714,122.45	67,749,910.00	255,964,212.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	144,953,071.00	66,089,410.00	78,863,661.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,458,000.00	1,660,500.00	2,824,500.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,453,234.38	19,965,000.00	86,488,234.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,580,458.00	19,965,000.00	11,615,458.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,580,458.00	7,095,000.00	23,485,458.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,000,000.00	12,870,000.00	-11,870,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох	74,872,776.38		74,872,776.38
210403	Төвлөрүүлэх шилжүүлэг.	74,872,776.38		74,872,776.38
22	Хөрөнгийн зардал	59,038,000.00		59,038,000.00
	Дотоод эх үүсвэрээр	59,038,000.00		59,038,000.00
223001	Бусад хөрөнгө	59,038,000.00		59,038,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/төгрөг/	
			Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			

I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,921,322.00	-4,921,322.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,921,322.00	-4,921,322.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,921,322.00	-4,921,322.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,965,209.00	-1,965,209.00
210402	Тээвэр, шатахуун		1,965,209.00	-1,965,209.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,956,113.00	-2,956,113.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,956,113.00	-2,956,113.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		4,921,322.00	-4,921,322.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		4,921,322.00	-4,921,322.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,000,000.00	-2,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,921,322.00	-2,921,322.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн "ctsystem" программ ашиглан бэлтгэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,372.9 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	69.7	851.7	782.0

Урьдчилгаа			
Бараа материал	244,434.4	289,048.9	44,614.5
Үндсэн хөрөнгө	1,898,955.1	1,825,185.6	-73,769.5
Нийт хөрөнгө	2,143,459.2	2,115,086.3	-28,372.9
Өр төлбөр	9,658.1	12,944.5	3,286.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,133,801.1	2,102,141.8	-31,659.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,143,459.2	2,115,086.3	-28,372.9

Мөнгөн хөрөнгийн дансны эхний болон эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 289,048.9 мянган төгрөг болж 44,614.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд бичиг хэргийн материал, аж ахуйн материал, барилгын засварын материал болон бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөнөөс голлон шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 1,825,185.6 мянган төгрөг болж 73,769.5 мянган төгрөгөөр буурсан нь тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн данснаас хөрөнгө акталсан болон шилжүүлсэн хөрөнгийн дүн мөн тайлант онд тооцсон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Өр төлбөрийн данс нь 12,944.5 мянган төгрөг болж 3,286.4 мянган өссөн нь тайлант онд ажилчидтай холбогдсон өглөг данс 9,144.9 мянган төгрөгөөр буурч, тээвэр шатахууны өглөг болон байгууллагад төлөх өглөг дансны үлдэгдэл 12,431.3 мянган төгрөг болж өссөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,102,141.8 мянган төгрөг болж 31,659.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс голлон шалтгаалсан байна.

2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 474,297.1 мянган төгрөгөөр буюу 26.9 хувиар буурсан байна. Орлого буурахад нэмэлт санхүүжилтийн орлого, орон нутгийн төсвөөс санхүүжих орлого, татварын бус орлого данс буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 38,610.2 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Зарлага буурахад эд хогшил, урсгал засварын зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал буурсан нь голлон нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,025,631.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 1,025,631.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 11 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 1,765,675.9 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 1,079,654.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 977,639.0 мянган төгрөг буюу 75.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 27,692.4 мянга, баг хорооны үйл ажиллагааны зардлыг

2,127.6 мянга, тогтмол зардлыг 1,401.0 мянга, нийтлэг үйлчилгээний зардлыг 400.6 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 233.5 төгрөг, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлыг 6,410.7 мянга, мал тооллогын зардлыг 1,200.0 мянга, хог хаягдал зайлуулах зардлыг 2.0 мянга, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлыг 15,821.2 мянга, ахмадын сангийн зардлыг 25.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	608,239.60	580,547.20	27,692.40	95%
2	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Баг хорооны ҮА-ны зардал-80106	211,860.30	209,732.70	2,127.60	99.00%
3	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106:Төрийн өмчийн барилгын тогтмол зардал-80111	47,369.70	45,968.70	1,401.00	97.04%
4	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Нийтлэг үйлчилгээ-80112	53,144.60	52,744.00	400.60	99.25%
5	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага 70106: Ажил олгогчоос олгох тэтгэмж-80802	20,198.50	19,965.00	233.50	98.84%
6	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Орон нутгийн нөөц хөрөнгө-81102	23,039.90	16,629.20	6,410.70	72.18%
7	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага 70106: Мал тооллого-81507	1,200.00	-	1,200.00	0%
8	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Хур хог хаягдал орчны бохирдол- 82212	2,594.00	2,592.00	2.00	100%
9	ОН-ийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106: Улсын баяр наадам- 82801	5,000.00	5,000.00	-	100.00%
10	Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх-71413 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх-81701	59,707.20	43,886.00	15,821.20	73.50%
11	Ахмад насны хөгжлийн хамгаалал-72208 Ахмадын сан-81549	600.00	574.20	25.80	95.70%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/
				Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	3,000.0	3,000.0	Си ти эс программ ашигладаг.
2	Унаа, хоолны зардал	0.0	0.0	Унаа хоолны зардал олгоогүй байна.
3	Сургалт, семинар	3,500.0	5,000.0	Хөдөөгийн багуудаар сургалт зохион байгуулсаны сургалтын хэрэглэгдэхүүн болон сургалт бэлтгэх материалын зардал, 5,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	0.0	Гадаад томилолтын зардал байхгүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	0.0	0.0	Орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл, мэдээлэл	0.0	0.0	Хэвлэл, мэдээллийн зардал байхгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,000.0 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,921.3 мянга, нийт 4,921.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс: тээвэр шатахууны зардалд 1,965.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 2,956.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтын дансны хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70106: Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	2,742.4	2,742.4	0,00	100%
2	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70106: Мал тооллого -81507	2,178.9	2,178.9	0,00	100%

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, харин байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах 8,957.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, программ хангамж, 32,609.0 мянган төгрөгийн бараа материалыг тайлант онд шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,300,867.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 13,008.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 10,406.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,309,403.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 13,094.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 10,475.2 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 162 мэдээлэл, хугацаа хоцроосон 7 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

Нас дэвшилт хийгээгүй	1	11,891.7		1	11,891.7	1	11,891.7				
Авлага бүртгээгүй.	1	692.7		1	692.7	1	692.7				
Дүн	2	12,584.4		2	12,584.4	2	12,584.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Дүн											
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
Дүн											
Нийт дүн											

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Г.БАТСҮХ/

2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр